Галуут сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө 1,896,984.6 мянган төгрөг байгаа бөгөөд өмнөх оноос 33,664.0 мянган төгрөгөөр буюу 1.8 хувиар өссөн байгаа нь үндсэн хөрөнгийн өсөлтөөс шалтгаалсан байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт* /мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 136,516.6 | 145,786.1 | 9,269.5 |
| Мөнгөн хөрөнгө | - | 24,535.0 | 24,535.0 |
| Авлага | 95.7 | 138.5 | 42.8 |
| Урьдчилгаа | - | - | - |
| Бараа материал | 136,420.9 | 121,112.6 | (15,308.3) |
| ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 1,726,803.9 | 1,751,198.4 | 24,394.5 |
| Үндсэн хөрөнгө | 2,035,158.9 | 2,121,996.8 | 86,838.0 |
| Хуримтлагдсан элэгдэл | (308,354.9) | (370,798.4) | (62,443.5) |
| **Нийт хөрөнгө** | **1,863,320.6** | **1,896,984.6** | **33,664.0** |
| Өр төлбөр | - | 265.4 | 265.4 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 1,863,320.6 | 1,896,719.2 | 33,398.6 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **1,863,320.6** | **1,896,984.6** | **33,664.0** |

Эх сурвалж: Байгууллагын 2022 оны санхүүгийн тайлан

Мөнгөн хөрөнгийн дансанд 24,535.0 мянган төгрөгийн үлдэгдэл илэрхийлсэн байна.

Авлага дансны үлдэгдэл тайлант оны эхэнд 95.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба оны эцэст барагдуулж 138.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй болж 42,8 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 121,112.6 мянган төгрөг болж өмнөх оноос 15,308.3 мянган төгрөгөөр буурсан нь бусад хангамжийн материалын данс 6,470.1 мянга, Аж ахуйн материалын данс 4,895.3 мянга, эм боох материал 1,189.1 мянган төгрөгөөр буурсан нь гол нөлөө үзүүлсэн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,121,996.8 мянган төгрөг болж 86,838.0 мянган төгрөгөөр өссөн нь Төсвийн хөрөнгөөр нийт 29,000.7 мянган төгрөг, хандив тусламжаар 3,785.8 мянга, шилжүүлэн авсан 54,051.4 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэсэн зэргээс шалтгаалсан байна.

Тайлант оны эхэнд өглөг байхгүй байсан бол тайлант оны эцэст 265.4 мянган төгрөгийн ажиллагсдад цалингийн тооцооны өглөгтэй гарсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,896,719.2 мянган төгрөг болж 33,398.6 мянган төгрөгөөр өссөн нь нь тайлант үеийн үр дүнгийн 33,398.6 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,081,006.3 мянга, нийт зарлагыг 1,081,006.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 74,208.2 мянган төгрөгөөр бууруулж 1,155,214.5 мянган төгрөгөөр анх батлагдсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 70701 хөтөлбөрийн 80101, 80224, 80802 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,155,214.5 мянган төгрөгийн төсөв баталж улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 978,962.6 мянга, Орон нутгийн төсвөөс 173,913.5 төгрөгийн санхүүжилт олгож, өөрийн орлогоор 2,338.7 мянган төгрөг төвлөрч оны эцэст 1,202.1 мянган төгрөгийн зарцуулаагүй үлдэгдлийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,129,477.6 мянган төгрөг буюу 97.8 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 25,737.2 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | 80312 Сургалт семинар | 1,544.8 | 1,531.8 | 13.1 | 99.2 |
| 2 | 81801 Үдийн цай | 52,508.8 | 50,125.0 | 2,382.8 | 95.5 |
| 3 | 81806 Дотуур байрны үйлчилгээ | 79,529.9 | 63,989.4 | 15,540.3 | 80.5 |
| 3 | 81816 Хүүхдэд ээлтэй сургалтын орчин | 29,970.0 | 29,913.1 | 56.9 | 99.8 |
| 4 | 81823 Боловсролын байгууллагын багш, | 6,951.6 | 6,730.2 | 221.4 | 96.8 |
| 5 | 81834 Боловсролын стандарт, сургалт | 715,028.9 | 708,912.4 | 6,116.5 | 99.1 |
| 6 | 81835 Сургалтын хэвийн үйл ажиллагаа | 86,786.0 | 86,582.4 | 203.6 | 99.8 |
| 7 | 80112 Нийтлэг үйлчилгээ | 173,913.5 | 172,711.4 | 1,202.1 | 99.3 |
| | Нийт дүн | 1,155,214.5 | 1,129,480.3 | 25,734.2 | 97.8 |

Эх сурвалж: Төсвийн гүйцэтгэлийн тайлангаас

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант хугацаанд байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд орлого, зарлагын гүйлгээ хийгдээгүй байна.

### *3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн*

| | ҮЗҮҮЛЭЛТ | ТӨЛӨВЛӨГӨӨ | ГҮЙЦЭТГЭЛ | Дүн | Хувь | ДАНС | Хүрсэн үр дүн |
|---|---|---|---|---|---|---|---|
| 688 | **ХӨТӨЛБӨР 71802** | - | - | - | - | | |
| 689 | **АРГА ХЭМЖЭЭ 80226** | - | - | - | - | | |
| 690 | I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 3,089,600 | 3,089,600 | - | 100.00 | 2 | Байгууллагын байр ашиглалттай холбоотой зардлын санхүүжилтийг цэвэрлэгээ, халдваргүйтгэл, эрүүл аюулгүй ажлын байрын орчин нөхцөлийн бүрдүүлэхэд зарцуулж ажиллалаа. |
| 691 | УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН | 3,089,600 | 3,089,600 | - | 100.00 | 21 | |
| 692 | Бараа, үйлчилгээний зардал | 3,089,600 | 3,089,600 | - | 100.00 | 210 | |
| 741 | Бараа үйлчилгээний бусад зардал | 3,089,600 | 3,089,600 | - | 100.00 | 2201 | |
| 742 | Бараа үйлчилгээний бусад зардал | 3,089,600 | 3,089,600 | - | 100.00 | 210901 | |
| 786 | **ХӨТӨЛБӨР 71802** | - | - | - | - | | |
| 787 | **АРГА ХЭМЖЭЭ 80312** | - | - | - | - | | |
| 788 | I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 1,544,800 | 1,531,750 | 13,050 | 99.20 | 2 | Багш нар сурагчидтай хамтран ажиллах, сургалт семинарын зардлыг шийдвэрлэснээр сурагчдын хөгжилд ахиц гарсан сайн үр дүнтэй байна. |
| 789 | УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН | 1,544,800 | 1,531,750 | 13,050 | 99.20 | 21 | |
| 790 | Бараа, үйлчилгээний зардал | 1,544,800 | 1,531,750 | 13,050 | 99.20 | 210 | |
| 839 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,544,800 | 1,531,750 | 13,050 | 99.20 | 2201 | |
| 840 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,544,800 | 1,531,750 | 13,050 | 99.20 | 210901 | |
| 982 | **ХӨТӨЛБӨР 71802** | - | - | - | - | | |
| 983 | **АРГА ХЭМЖЭЭ 81605** | - | - | - | - | | |
| 984 | I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 3,553,000 | 3,553,000 | - | 100.00 | 2 | Эрт илрүүлдгийн үзлэгт хуваарийн дагуу 29 багш хамрагдаж оношлуулсан нэгдсэн эмнэлэгтэй гэрээ байгуулж 870000 төгрөгийн эрүүл мэндийн үзлэгийн зардлыг холбогдох баримтыг үндэслэн гүйлгээ хийсэн.Шинжилгээний Бод Лаб хувийн лабораторитой гэрээ байгуулан 35 багш 12 төрлийн 2683000 төгрөгийн шинжилгээг орон нутагт иргүүлж ажилласан. |
| 985 | УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН | 3,553,000 | 3,553,000 | - | 100.00 | 21 | |
| 986 | Бараа, үйлчилгээний зардал | 3,553,000 | 3,553,000 | - | 100.00 | 210 | |
| 1035 | Бараа үйлчилгээний бусад зардал | 3,553,000 | 3,553,000 | - | 100.00 | 2201 | |
| 1036 | Бараа үйлчилгээний бусад зардал | 3,553,000 | 3,553,000 | - | 100.00 | 210901 | |
| 1080 | **ХӨТӨЛБӨР 71802** | - | - | - | - | | |
| 1081 | **АРГА ХЭМЖЭЭ 81801** | - | - | - | - | | |
| 1082 | I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 52,508,800 | 50,126,040 | 2,382,760 | 85.91 | 2 | Үдийн хоол хөтөлбөрт 1-5 дугаар ангийн сурагчид хамрагдан, БЕГ-ын загвар менюны дагуу сэт хоолны үйлчилгээнд хамрагдав. Хэрэглэгчдийн сэтгэл ханамж нэмэгдсэн үр дүнтэй байлаа. |
| 1083 | УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН | 52,508,800 | 50,126,040 | 2,382,760 | 85.91 | 21 | |
| 1146 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 52,508,800 | 50,126,040 | 2,382,760 | 85.91 | | |
| 1150 | Бусад урсгал шилжүүлэг | 52,508,800 | 50,126,040 | 2,382,760 | 85.91 | 2132 | |
| 1154 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, дэмжлэг | 52,508,800 | 50,126,040 | 2,382,760 | 85.91 | 213205 | |
| 1178 | **ХӨТӨЛБӨР 71802** | - | - | - | - | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1179 | **АРГА ХЭМЖЭЭ 81806** | - | - | - | - | | |
| 1180 | I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 75,529,900 | 63,899,798 | 15,630,101 | 80.30 | 2 | Сургуулийн дотуур байранд 80 хүүхэд амьдарч, дотуур байрын үйлчилгээ авч байна. Дотуур байранд багш 1, жижүүр 4, тогооч 2, үйлчлэгч 1 ажиллаж дотуур байрын сурагчдад үйлчилгээ үзүүлж ажиллалаа. Нормативын дагуу хоол хүнсээр хэвийн тасралтгүй хангаж ажиллав.Давхардсан тоогоор 13196 хүүхэд дотуур байранд байрласан байна. |
| 1181 | УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН | 79,529,900 | 63,899,798 | 1,563,101 | 80.30 | 21 | |
| 1182 | Бараа, үйлчилгээний зардал | 79,529,900 | 63,899,798 | 15,630,101 | 80.30 | 210 | |
| 1183 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 13,302,400 | 13,211,808 | 90,591 | 99.30 | 2101 | |
| 1184 | Үндсэн цалин | 13,302,400 | 12,431,644 | 870,755 | 93.50 | 210101 | |
| 1185 | Нэмэгдэл | | 309,100 | (309,100) | | | |
| 1186 | Урамшуулал | | 471,064 | (471,064) | | | |
| 1189 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 1,662,700 | 1,662,700 | - | 100.00 | 2102 | |
| 1190 | Тэтгэврийн даатгал | 1,130,700 | 1,130,700 | - | 100.00 | 210201 | |
| 1191 | Тэтгэмжийн даатгал | 133,000 | 133,000 | - | 100.00 | 210202 | |
| 1192 | ҮОМШӨ ний даатгал | 106,400 | 108,400 | (2,000) | 101.00 | 210203 | |
| 1193 | Ажилгүйдлийн даатгал | 26,600 | 24,600 | 2,000 | 92.50 | 210204 | |
| 1194 | Эрүүл мэндийн даатгал | 266,000 | 266,000 | - | 100.00 | 210205 | |
| 1208 | Нормативт зардал | 61,449,800 | 45,917,540 | 15,532,260 | 74.70 | 2105 | |
| 1210 | Хоол, хүнс | 61,449,800 | 45,917,540 | 15,532,260 | 74.70 | 210502 | |
| 1231 | Бараа үйлчилгээний бусад зардал | 3,115,000 | 3,107,750 | 7,250 | 99.80 | 2201 | |
| 1232 | Бараа үйлчилгээний бусад зардал | 3,115,000 | 3,107,750 | 7,250 | 99.80 | 210901 | |
| 1276 | **ХӨТӨЛБӨР 71802** | - | - | - | - | | |
| 1277 | **АРГА ХЭМЖЭЭ 81816** | - | - | - | - | | |
| 1278 | I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 29,970,000 | 29,913,100 | 56,900 | 99.80 | 2 | Цахим шилжилттэй холбоотойгоор төрөөс сургалтын тоног төхөөрөмжөөр нөхөн хангах зардал шийдэгдсэнээр манай сургууль 2 зөөврийн компьютер, 25 таблет бүхий цахим сургалтын танхимыг шинээр байгуулж ажиллалаа. |
| 1279 | УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН | 29,970,000 | 29,913,100 | 56,900 | 99.80 | 21 | |
| 1280 | Бараа, үйлчилгээний зардал | 29,970,000 | 29,913,100 | 56,900 | 99.80 | 210 | |
| 1329 | Бараа үйлчилгээний бусад зардал | 29,970,000 | 29,913,100 | 56,900 | 99.80 | 2201 | |
| 1330 | Бараа үйлчилгээний бусад зардал | 29,970,000 | 29,913,100 | 56,900 | 99.80 | 210901 | |
| 1374 | **ХӨТӨЛБӨР 71802** | - | - | - | - | | |
| 1375 | **АРГА ХЭМЖЭЭ 81823** | - | - | - | - | | |
| 1376 | I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 6,951,600 | 6,730,200 | 221,400 | 96.80 | 2 | Багшийн сургалтын үйл ажиллагааны зардал шийдвэрлэгдсэнээр модуль сургалтад 32 багш хамрагдсан мөн үнэлгээний арга зүйн сургалт аймгийн БГ газраас сургалт хийсэн,цахим журнал хөтлөх болон компьютерын сургалтад хамрагдсан зардлууд гарсан. мэргэжлийн ЗАН, багш нарын хамтын ажиллагаа сайжирч, багш бүрийн хөгжилд чанарын ахиц гарч байна. |
| 1377 | УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН | 6,951,600 | 6,730,200 | 221,400 | 96.80 | 21 | |
| 1378 | Бараа, үйлчилгээний зардал | 6,951,600 | 6,730,200 | 221,400 | 96.80 | 210 | |
| 1427 | Бараа үйлчилгээний бусад зардал | 6,951,600 | 6,730,200 | 221,400 | 96.80 | 2201 | |
| 1428 | Бараа үйлчилгээний бусад зардал | 6,951,600 | 6,730,200 | 221,400 | 96.80 | 210901 | |
| 1472 | **ХӨТӨЛБӨР 71802** | - | - | - | - | | |
| 1473 | **АРГА ХЭМЖЭЭ 81834** | - | - | - | - | | |
| 1474 | I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 715,028,900 | 709,992,109 | 5,036,790 | 99.30 | 2 | 2022 онд багш тус бүрд цахим хэрэглээний зардал, хичээл үйлдвэрлэлийн зардлыг тооцон олгодог болсон ба эдгээр зардлын төлөвлөлт, хэрэгжилт, |
| 1475 | УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН | 715,028,900 | 709,992,109 | 5,036,790 | 99.30 | 21 | |
| 1476 | Бараа, үйлчилгээний зардал | 715,028,900 | 709,992,109 | 5,036,790 | 99.30 | 210 | |
| 1477 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 614,984,000 | 612,062,769 | 2,921,230 | 99.50 | 2101 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1478 | Үндсэн цалин | 436,455,200 | 440,445,351 | (3,990,151) | 100.90 | 210101 | гүйцэтгэлийн алхам бүрд багшийн оролцоог хангаж ажилласнаар багшийн санхүүгийн үйл ажиллагаанд оролцох оролцоог нэмэгдүүлж, сургалтын хэрэглэгдэхүүнээ багш өөрөө төлөвлөн худалдан авах боломжийг бүрдүүлж өгсөн сайн талтай ажил болсон. Эдгээр зардлууд нь цахим шилжилтийн цаг үед багшид тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэж чадсан тул багш нар сэтгэл ханамж өндөр байсан. Мөн төсвийн шинэчлэлийн хүрээнд 5 ажлын хэсэг захирлын тушаалаар томилогдон өөрсдөө улирлаар төлөвлөгөө гарган төсвөө 170 дугаар журмын дагуу зарцуулж байна.Үр дүнгийн гүйцэтгэлийн үнэлгээгээр 10 багш үнэлэгдэн үр дүнгийн урамшуулал олгосон. |
| 1479 | Нэмэгдэл | 166,065,200 | 157,815,944 | 8,249,256 | 95.00 | 210102 | |
| 1481 | Урамшуулал | 12,463,600 | 13,801,474 | (1,337,874) | 110.70 | 210104 | |
| 1483 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 76,873,000 | 74,873,000 | 2,000,000 | 97.40 | 2102 | |
| 1484 | Тэтгэврийн даатгал | 52,273,600 | 51,184,700 | 1,088,900 | 97.90 | 210201 | |
| 1485 | Тэтгэмжийн даатгал | 6,149,800 | 6,089,400 | 60,400 | 99.00 | 210202 | |
| 1486 | ҮОМШӨ ний даатгал | 4,919,900 | 4,737,400 | 182,500 | 96.30 | 210203 | |
| 1487 | Ажилгүйдлийн даатгал | 1,230,000 | 1,169,400 | 60,600 | 95.10 | 210204 | |
| 1488 | Эрүүл мэндийн даатгал | 12,299,700 | 11,692,100 | 607,600 | 95.10 | 210205 | |
| 1515 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр | 7,724,000 | 7,617,450 | 105,660 | 98.60 | 2108 | |
| 1521 | Мэдээллийн технологийн зардал | 7,724,000 | 7,617,450 | 106,550 | 98.60 | 210806 | |
| 1525 | Бараа үйлчилгээний бусад зардал | 15,447,900 | 15,438,889 | 9,010 | 99.90 | 2201 | |
| 1526 | Бараа үйлчилгээний бусад зардал | 3,862,000 | 3,852,989 | 9,010 | 99.80 | 210901 | |
| 1527 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 11,585,900 | 11,585,900 | - | 100.00 | 210902 | |
| 1570 | **ХӨТӨЛБӨР 71802** | - | - | - | - | | |
| 1571 | **АРГА ХЭМЖЭЭ 81835** | - | - | - | - | | |
| 1572 | I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 86,786,000 | 85,595,261 | 1,190,738 | 98.60 | 2 | 2022 онд сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах хүрээнд олгогдсон төсвийн хүрээнд тухайн ангилалд хамаарах ажилтны цалин хөлс, нэмэгдэл урамшууллыг шийдвэрлэж олгосон.Давхардсан тоогоор 76 хүн үр дүнгийн урамшуулал авсан байна. |
| 1573 | УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН | 86,786,000 | 85,595,261 | 1,190,738 | 98.60 | 21 | |
| 1574 | Бараа, үйлчилгээний зардал | 86,786,000 | 85,595,261 | 1,190,738 | 98.60 | 210 | |
| 1575 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 77,143,100 | 75,952,361 | 1,190,738 | 98.50 | 2101 | |
| 1576 | Үндсэн цалин | 64,700,000 | 59,986,333 | 4,713,666 | 92.70 | 210101 | |
| 1577 | Нэмэгдэл | 5,176,000 | 7,452,941 | (2,276,941) | 144.00 | 210102 | |
| 1579 | Урамшуулал | 7,267,100 | 8,513,086 | (1,245,986) | 117.10 | 210104 | |
| 1581 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 9,642,900 | 9,642,900 | - | 100.00 | 2102 | |
| 1582 | Тэтгэврийн даатгал | 6,557,200 | 6,557,200 | - | 100.00 | 210201 | |
| 1583 | Тэтгэмжийн даатгал | 771,400 | 771,400 | - | 100.00 | 210202 | |
| 1584 | ҮОМШӨ ний даатгал | 617,100 | 617,100 | - | 100.00 | 210203 | |
| 1585 | Ажилгүйдлийн даатгал | 154,300 | 154,300 | - | 100.00 | 210204 | |
| 1586 | Эрүүл мэндийн даатгал | 1,542,900 | 1,542,900 | - | 100.00 | 210205 | |
| 1766 | **ХӨТӨЛБӨР 71802** | - | - | - | - | | |
| 1767 | **АРГА ХЭМЖЭЭ 81848** | - | - | - | - | | |
| 1768 | I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 2,338,700 | 2,335,400 | 3,300 | 99.90 | 2 | Сурах бичгийг түрээсээр эзэмшүүлэх журмын дагуу шаардлагатай сурагчдад түрээсийн сурах бичгээр үйлчлэн, орлогыг төвлөрүүлэн ажилласнаар сургуулийн хэмжээнд сурах бичгийн хангамж 99.9-тай ажиллаж байна. |
| 1769 | УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН | 2,338,700 | 2,335,400 | 3,300 | 99.90 | 21 | |
| 1770 | Бараа, үйлчилгээний зардал | 2,338,700 | 2,335,400 | 3,300 | 99.90 | 210 | |
| 1809 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр | 2,338,700 | 2,335,400 | 3,300 | 99.90 | 2108 | |
| 1810 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 2,338,700 | 2,335,400 | 3,300 | 99.90 | 210801 | |

# 4. АУДИТЫН ТАЙЛАН

## 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Галуут сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Азбаяр гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер А.Цэзням, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Галуут сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 1 дүгээр сарын 25-ны өдөр ирүүлсэн.

2022 оны төсвийн хөрөнгийг захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг Галуут сумын Ерөнхий боловсролын сургуулийн дарга С.Цэгмид, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч С.Ариунжаргал нар зурж байна.

## 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр төсвийн гүйцэтгэлийн нийт зардлыг сонгож, материаллаг байдлын түвшин 1.0 хувиар тооцож материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг "Дунд" гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны батлагдсан төсвийн 1,201,546.4 мянган төгрөгөөс 12,015.5 мянган төгрөг, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 70 хувиар буюу 8,410.8 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

## 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тухайн байгууллага нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хязгаарлалттай холбоотой заалтуудыг зөрчөөгүй болно.

## 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь 2022 онд нийт 1,155,214.8 мянган төгрөгийн 151 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас иж бүрэн мэдээллийг хугацаанд нь байршуулсан байна.

| д/д | Хугацаа | Төрөл | Удаа | Хугацаанд байршуулсан | Хугацаа хоцроож байршуулсан | Хугацаа болоогүй |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Бүтэн жил | 11 | 11 | 1 | 8 | 2 |
| 2 | Хагас жил | 4 | 4 | 2 | 2 | 0 |
| 3 | Улирал бүр | 1 | 4 | 3 | 1 | 0 |
| 4 | Сар бүр | 3 | 36 | 28 | 8 | 0 |
| 5 | Тухай бүр | 8 | 96 | 85 | 11 | 0 |
| 6 | Нийт | 27 | 151 | 119 | 30 | 2 |

Аудитаар тендер шалгаруулах худалдан авах ажиллагаа-1, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ 1,155,214.8 мянган төгрөгийн 12 гүйлгээ, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ 226,442.6 мянган төгрөгийн 21 гүйлгээ, өмч хөрөнгөтэй холбоотой төгрөгийн 91 шийдвэрийн мэдээллийг мэдээлсэн байна.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар хийсэн аудитаар 22,720.5 мянган төгрөгийн зөрчил илэрсэнд аудитын явцад 19,068.6 мянган төгрөгийн зөрчлийг арилгаж жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар 3,651.9 мянган төгрөгийн 2 зөрчилд зөвлөмж өгөв.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар 586.6 мянган төгрөгийн 2 алдаа, зөрчил илэрснээс 586.6 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой 1 зөрчилд зөвлөмж хүргүүлсэн ба Галуут сумын Ерөнхий боловсролын сургуулийн даргын 2022.05.30-ны өдрийн 14 дугаар албан бичгээр хэрэгжилтийг тооцсон байна.

*Хүснэгт 5. Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | 1 | 586.6 | 1 | 586.6 | 100 |
| Зөвлөмж | 1 | 0 | 1 | 0 | 100 |
| **Нийт дүн** | **2** | **586.6** | **2** | **586.6** | **100** |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Засгийн газрын 2019 оны 450 дугаар тогтоол "Хоолны зардлын норматив тогтоох тухай"-ын 4-т "Нэг хүүхдэд ногдох хоолны зардлын гүйцэтгэлийг хүүхэд-өдрөөр хянаж, зөрүүг нь тооцож байх"-ыг БСШУСС, Сангийн сайд болон аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасан ба 2022 оны 1, 2 дугаар саруудад бүрэн ажиллаагүй, хоолны ирцэд хяналт тавьснаар дотуур байрны хоолны зардал 15532.0 мянга, Үдийн цай хөтөлбөрийн зардал 2382.7 мянган төгрөгөөр тус тус хэмнэгдсэн байхад төсөвт төвлөрүүлээгүй ба харилцах дансанд үлдэгдлээр байна. Энэ асуудлыг Боловсролын ерөнхий газрын хэмжээнд нэгтгэн анхаарч авч үзэх шаардлагатай байна..

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 3,651.9 мянган төгрөгийн зөрчил[1] илэрч, зөрчлийг давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өгөв.

### 5.1 Зөвлөмж

1.Өөрийн харьяанд бүртгэлтэй худгаар ус түгээж, 1,835.0 мянган төгрөгийн орлого оруулан нярав тооцоог хийж бүртгэж байгаа ч нягтлан бодох бүртгэлд тусгаагүй байсныг завсрын аудитаар илрүүлэн залруулсан.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4-т заасан "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.2-т заасан "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага" гэсэн заалтыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь**: Цаашид нэмэлтээр орж буй орлогыг цаг тухай бүрд нь дансанд төвлөрүүлэн нягтлан бодох бүртгэлийг тасралтгүй, үнэн зөв бүртгэж байх зөвлөмжийг хүргүүлэв.

2. Мөнгөн хөрөнгийн дансны гүйлгээг анхан шатны баримттай тулган шалгахад 1,816.9 мянган төгрөгийн 5 гүйлгээнд Е баримтгүй гүйлгээ хийсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.6-д заасан "20.2.6.эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;", Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.1-т "Энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд заасан орлогын дүнд энэ хуулийн 21.1-д заасан хувиар албан татвар ногдуулж, холбогдох төсөвт шилжүүлэх", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14.3-т "Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь**: Бэлтгэн нийлүүлэгчээс Е баримтгүй хийсэн хавсралтад заасан гүйлгээнд баримтыг нөхөн бүрдүүлж 69,957.6 мянган төгрөгийн 10 хувьд ногдох 6,957.6 мянган төгрөгийг төсөвт төвлөрөх нөхцөлийг үүсгэх зөвлөмжийг хүргүүлэв.

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

3. Шилэн дансны цахим сайтад цахилгаан эрчим хүч, цэвэр бохир усаар үйлчлэх гэрээг байршуулаагүй, мөн нийт 151 мэдээ мэдээлэхээс 30 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Энэ нь Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6.1-т заасан "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ", 6.4-т заасан Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь**: Шилэн дансны цахим сайтад хуульд заасан мэдээллийг цаг хугацаанд нь мэдээлж байх зөвлөмжийг хүргүүлэв.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг бүрэн хангаж, нотлох баримтыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 04 дүгээр сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

| Зөрчлийн утга | Нийт зөрчил | | Үүнээс: | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Өөрийн харьяанд бүртгэлтэй худгаар ус түгээж, 1,835.0 мянган төгрөгийн орлого оруулан нярав тооцоог хийж бүртгэж байгаа ч нягтлан бодох бүртгэлд тусгаагүй байсныг завсрын аудитаар илрүүлэн залруулсан. | 1 | 1,835.0 | | | | | 1 | 1,835.0 |
| Мөнгөн хөрөнгийн дансны гүйлгээг анхан шатны баримттай тулган шалгахад 1,816.9 мянган төгрөгийн 5 гүйлгээнд Е баримтгүй гүйлгээ хийсэн байна. | 1 | 1,816.9 | | | | | 1 | 1,816.9 |
| **ДҮН** | **2** | **3,651.9** | | | | | **2** | **3,651.9** |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал (мянган төгрөгөөр)**

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Шилэн дансны цахим сайтад цахилгаан эрчим хүч, цэвэр бохир усаар үйлчлэх гэрээг байршуулаагүй | 1 | 0 | | | | | 1 | 0 |
| **Дүн** | **1** | | **0** | **0** | **0** | **0** | **1** | |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| Дүн | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| **Нийт дүн** | **1** | **0** | **0** | **0** | **0** | **0** | **1** | **0** |

-oOo-